



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/05/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага.....	12
3.5.3 Урьдчилгаа.....	12
3.5.4 Бараа материал	12
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	13
3.5.6 Үндсэн хөрөнгө	13
3.5.7 Өр төлбөр.....	14
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.3 Зөвлөмж.....	211
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	22
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	22
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/244
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Заамар сум нь Монгол Улсын Засгийн газраас “Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн” өрнүүлж, цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралыг даван туулах, баялаг бүтээгчдээ дэмжих эрхэм зорилгыг хэрэгжүүлэхээр “Ногоон хөгжил баялаг бүтээгчдийг” дэмжих урианы жил болгон зарлаж ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Баялаг бүтээгчдийг дэмжих” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 21 чиглэлийн 184 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 83.22%-тай биелүүлж, “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Энэ нь Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны 10/84 тоот албан бичгийн дагуу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулиудын 7,918,499.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 440,528.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан байна.

Сумын нутаг дэвсгэр дээр уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдтэй "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" нийгмийн хариуцлагын 8 гэрээний хүрээнд 720,393.8 мянган төгрөгийн 34 төрлийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,142,314.5	3,139,155.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,038,759.6	2,217,686.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	562,551.6	733,105.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	541,003.3	188,363.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		11,786,009.6	4,115,987.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	11,786,009.6	4,115,987.5
39200	Биет хөрөнгө		10,952,889.0	3,384,007.7
39300	Биет бус хөрөнгө	13	833,120.6	731,979.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		13,928,324.1	7,255,143.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		162,213.5	177,312.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	162,213.5	177,312.7
41300	Өглөг	17а, 17б	162,213.5	177,312.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		13,766,110.6	7,077,830.3
51	Засгийн газрын хувь оролцоо		13,766,110.6	7,077,830.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		4,104,924.2	2,319,415.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		4,104,924.2	2,319,415.2
51200	Хуримтлагдсан үр дүн		7,071,202.4	4,317,183.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,589,984.0	441,231.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		13,928,324.1	7,255,143.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		10,446,260.1	4,547,684.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		792,695.1	3,161,053.1
110	Орлогын албан татвар		232,966.8	2,573,209.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		232,966.8	2,595,929.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-22,720.1
113	Хөрөнгийн албан татвар		84,392.7	110,954.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		475,335.6	476,889.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,911,596.4	644,525.8
120	Нийтлэг татварын бус орлого		3,911,596.4	644,525.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,741,968.6	742,106.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	7,021,523.4	2,401,677.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,021,523.4	2,185,890.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,332,278.6	1,686,469.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,779,518.9	365,730.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		365,369.3	46,759.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		464,669.8	502,449.7
2104	Хангамж, бараа материалын зардал		110,383.4	109,952.5
2105	Нормативт зардал		309,265.0	7,872.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		49,428.6	47,573.0
2107	Томилолт, зочны зардал		7,024.9	10,606.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		16,828.2	157,983.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,229,790.4	437,542.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,659,016.8	499,420.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	215,787.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		3,424,736.7	2,146,007.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		52,753.4	5,707,799.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		3,392,144.7	-3,561,792.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,637,887.4	4,313,584.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	792,695.1	3,161,053.1
110	Орлогын албан татвар	232,966.8	2,573,209.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	232,966.8	2,595,929.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-22,720.1
113	Хөрөнгийн албан татвар	84,392.7	110,954.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	475,335.6	476,889.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	28,604.9	32,177.1
1181	Газрын төлбөр	446,730.7	444,712.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	373,943.0	393,631.1
120	Нийтлэг татварын бус орлого	373,943.0	393,631.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,471,249.4	758,900.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,004,885.3	2,037,226.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,004,885.3	2,037,226.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,298,846.3	1,482,668.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,778,811.7	365,730.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	365,369.3	46,274.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	457,387.8	492,117.9
2104	Хангамж, бараа материалын зардал	99,238.5	113,994.3
2105	Нормативт зардал	337,306.6	62,086.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,472.5	56,227.9
2107	Томилолт, зочны зардал	7,024.9	10,606.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,440.7	158,576.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,794.4	177,054.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,675,810.9	554,557.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	633,002.2	2,276,357.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	65,642.0	1,094,367.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,642.0	1,094,367.0
2200	Дотоод эх үүсвэрээр	65,642.0	1,094,367.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-65,642.0	-1,094,367.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-67,531.5	-3,063.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	67,531.5	3,063.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	499,828.7	1,178,927.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	538,930.9	1,038,759.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,038,759.6	2,217,686.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,373,965.9	10,373,965.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	185.1	185.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,374,151.1	10,374,151.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-185.1	-185.1
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	3,392,144.7	3,392,144.7
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,766,110.6	13,766,110.6
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,766,110.6	13,766,110.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,127,790.7	-3,127,790.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,638,319.9	10,638,319.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	1,302.5	1,302.5
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-3,561,792.1	-3,561,792.1
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,077,830.3	7,077,830.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	581,110.5	48,211.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,114.5	48,211.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,637.06	16,933.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,637.88	2,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,765.62	1,867.84
2105	Нормативт зардал	159,805.12	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,745.56	6,892.90
2107	Томилолт, зочны зардал	297.60	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,396.36	500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,988.92	5,272.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	303,477.47	31,278.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	286,501.22	279.25
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,976.26	30,999.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,996.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,996.00	0.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	601,279.23	28,043.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	601,279.23	28,043.10
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	20,168.70	-20,168.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20,168.70
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,168.70	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,855,283.9	2,416,049.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,405,052.2	1,336,698.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,387,876.7	1,319,523.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,484.5	365,730.5
210101	Үндсэн цалин	304,569.9	296,966.4
210102	Нэмэгдэл	79,470.3	51,261.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	672.0
210104	Урамшуулал	20,444.3	16,830.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,413.8	46,274.5
210201	Тэтгэврийн даатгал	36,583.7	31,726.3
210202	Тэтгэмжийн даатгал	3,957.5	3,728.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,165.9	2,922.0
210204	Ажилгүйдлийн даатгал	791.7	714.8
210205	Эрүүл мэндийн даатгал	7,915.0	7,183.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	500,464.6	489,717.9
210301	Гэрэл, цахилгаан	52,414.8	81,798.0
210302	Түлш, халаалт	430,937.0	403,197.5
210303	Цэвэр, бохир ус	17,112.8	4,722.4
2104	Хангамж, бараа материалын зардал	108,660.5	108,660.5
210401	Бичиг хэрэг	9,256.0	9,213.2
210402	Тээвэр, шатахуун	74,283.7	74,008.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,620.8	4,939.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,500.0	20,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,335.0	49,335.0
210604	Урсгал засвар	49,335.0	49,335.0
2107	Томилолт, зочны зардал	11,659.0	10,606.9
210702	Дотоод албан томилолт	11,659.0	10,606.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169,629.3	157,968.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,784.4	156,131.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	468.0	468.0
210803	Даатгалын үйлчилгээ	130.6	130.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,246.3	1,238.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,230.0	91,230.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,730.0	87,730.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500.0	3,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,175.5	17,175.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,175.5	17,175.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,675.5	12,675.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500.0	4,500.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,270,231.7	1,076,287.0
220001	Барилга байгууламж	621,680.4	99,300.0
221001	Их засвар	806,931.4	571,064.2
222001	Тоног төхөөрөмж	50,680.0	43,216.0
223001	Бусад хөрөнгө	790,939.9	362,706.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	180,000.0	3,063.6
230001	Эргэж төлөгдөх зээл	180,000.0	3,063.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,855,283.9	2,592,777.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	730,857.0	730,857.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	730,857.0	730,857.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,388,070.3	1,772,592.2
320001	Орон нутгийн төсвөөс	2,388,070.3	1,772,592.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	736,356.6	89,328.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,000.0	89,328.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	556,356.6	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.0	616,946.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.0	758,705.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Баялаг бүтээгчдийг дэмжих” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 21 чиглэлийн 184 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 83,22%-тай биелүүлж, “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Тус суманд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих сумын төвөөс Баянхангай сум хүртэлх хатуу хучилттай замын ажил эхэлж, сумын цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын гүйцэтгэл 70%-тай явагдаж, хөл бөмбөгийн талбайн ажил бүрэн хийгдэж ашиглалтад орсон, шинээр цэвэрлэх байгууламж барих ажил эхэлсэн үйл явдал болсон байна.

Төв аймгийн Заамар сумын төсөвт байгууллагууд удирдах 14, гүйцэтгэх 144, үйлчилгээний 63, нийт 221 орон тоотой баталж, гүйцэтгэлээр 219 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Заамар сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2022 онд нийт 6 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төсвийн 9 байгууллагад байгууллагын даргын тушаалаар тооллогын комисс гарган, хагас бүтэн жилээр тооллогыг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж, үндсэн хөрөнгийг төрийн өмчийн программд бүрэн оруулсан байна.

Төв аймгийн Заамар сумын төсөвт байгууллагуудын барилга байгууламж, машин техник тоног төхөөрөмжийг Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71-р тушаалтын 2 дугаар хавсралтаар баталсан маягтаар хувийн хэрэг нээж паспортжуулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулсан байна.

Заамар сумын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нэгтгэсэн тайланд хамрагдаж байгаа 14 байгууллагаас ЗДТГ, Заамар ерөнхий боловсролын сургууль, Шижир алт сургууль, Шижир алт цэцэрлэг, эрүүл мэндийн төв 6 байгууллага “өөрчлөлтгүй” дүгнэлт, Заамар хөгжил ОНӨААТҮГ, Заамар цэцэрлэг “хязгаарлалттай” дүгнэлт авч, ИТХ, соёлын төв, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, эргэлтийн эмийн сан, орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сан нь түүвэрт хамрагдсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,673,181.1 мянган төгрөгөөр буюу 47,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,038,759.6	2,217,686.6	1,178,927.0
Авлага	562,551.6	733,105.2	170,553.6
Бараа материал	541,003.3	188,363.6	-352,639.7
Үндсэн хөрөнгө	11,786,009.6	4,115,987.5	-7,670,022.1
Нийт хөрөнгө	13,928,324.1	7,255,143.0	-6,673,181.1
Өр төлбөр	162,213.5	177,312.7	15,099.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	13,766,110.6	7,077,830.3	-6,688,280.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,928,324.1	7,255,143.0	-6,673,181.1

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,217,686.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,178,927.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,029,665.6 мянган төгрөгөөр өсөж 1,211,978.5 мянган төгрөг болсон, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 86,264.6 мянган төгрөгөөр өсөж 204,758.2 мянган төгрөг болсон, эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл 18,818.6 мянган төгрөгөөр өсөж 46,584.2 мянган төгрөг болсон, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 90,463.4 мянган төгрөгөөр өсөж 553,947.0 мянган төгрөг болж өссөн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 733,105.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 170,553.6 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 285,745.7 мянган төгрөгийн авлагыг шилжүүлж, Сум хөгжүүлэх сан /Хоршоо хөгжүүлэх сан/-гийн

77,195.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн цэвэрлэх байгууламжийн ажил дуусгавар болж хүлээн аваагүйн улмаас 537,820.6 мянган төгрөгийн авлага шинээр үүсгэсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 188,363.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 352,639.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 440,528.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,115,987.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,670,022.1 мянган төгрөгөөр буурсан нь үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 7,918,499.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж тайлагнаснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 177.312.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,099.2 мянган төгрөгөөр өссөн нь байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн өглөг 7,537.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, эргэлтийн эмийн санд 976.7 мянган төгрөгөөр, Заамар хөгжил ОНӨААТҮГ-т 12,549.3 мянган төгрөгөөр шинээр өглөг үүссэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 7,077,830.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,688,280.3 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, өглөг, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 3,561,792.1 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,217,686.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,178,927.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0	7,576.7	7,576.7
Төгрөг	0	7,576.7	7,576.7
Арилжааны банк дахь кассын харилцах	0	7,576.7	7,576.7
Банканд байгаа бэлэн мөнгө	1,038,759.6	2,210,109.9	1,171,350.3
Төгрөг	1,038,759.6	2,210,109.9	1,171,350.3
Төрийн сангийн харилцах	1,010,994.0	2,148,286.3	1,137,292.3
Арилжааны банк дахь харилцах	27,765.6	61,823.6	34,058.0
Дүн	1,038,759.6	2,217,686.6	1,178,927.0

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 2,148,286.3 мянган төгрөгийн 56,4 хувь буюу 1,211,978.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 25,8 хувь буюу 553,947.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн, 9,5 хувь буюу 204,758.2 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 8,3 хувь буюу 177,602.6 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансанд эмийн эргэлтийн сангийн 46,584.2 мянган төгрөг, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 15,239.4 мянган төгрөгийн үлдэгдэл байна. Арилжааны банк дахь кассад Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 7,576.7 мянган төгрөг байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 1,192,429.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өмнөх оноос 1,029,665.6 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 90,463.4 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 86,264.6 мянган төгрөгөөр, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн үлдэгдэл тус тус өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Эмийн эргэлтийн сан арилжааны банк дахь харилцахын оны эхний үлдэгдэл 27,765.6 мянган төгрөг, эм бараа борлуулалтын орлого 72,231.0 мянган төгрөг, урьд оны авлагаас 1,282.5 мянган төгрөг харилцах дансанд төвлөрүүлсэн. Эм бараа материал худалдан авахад 51,994.9 мянган төгрөг, урамшуулалд 1,889.9 мянган төгрөг, бар код уншигч машинд 480.0 мянган төгрөг, бусад зардалд 330.0 мянган төгрөг нийт 54,694.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, харилцах дансны эцсийн үлдэгдэл 46,584.2 мянган төгрөг тохирч байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 733,105.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 170,553.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0	450.0	450.0
Зээлийн хүүгийн авлага	13,150.4	11,732.1	-1,418.3
Байгууллагаас авах авлага	373,325.0	618,834.8	245,509.8
Хувь хүмүүсээс авах авлага	176,076.1	102,088.3	-73,987.8
Дүн	562,551.6	733,105.2	170,553.7

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 733,105.2 мянган төгрөгийн 13,9 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 84,4 хувийг байгууллагаас авах авлага, 1,6 хувийг зээлийн хүүгийн авлага, 0,1 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 99,8 хувь буюу 202,255.6 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 33,1 хувь буюу 25,925.5 мянган төгрөгийн авлага нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна.

Авлага дансны үлдэгдэл 733,105.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 170,553.6 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 285,745.7 мянган төгрөгийн авлагыг шилжүүлж, Сум хөгжүүлэх сан /Хоршоо хөгжүүлэх сан/-гийн 77,195.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан бөгөөд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлсэн 10,830.4 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн, эмийн эргэлтийн сангийн нийгмийн даатгалын байгууллагад илүү төлсөн авлага 1,485.2 мянган төгрөгийн шимтгэлийг авлагаар бүртгэж, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 1,461.5 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн цэвэрлэх байгууламжийн ажил дуусгавар болж хүлээн аваагүйн улмаас 537,820.6 мянган төгрөгийн авлага шинээр үүсгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн цэвэрлэх байгууламжийн ажил дуусгавар болж хүлээн аваагүйн улмаас 537,820.6 мянган төгрөгийн авлага шинээр үүсгэсэн байна. Хоршоо хөгжүүлэх сангийн 181,507.5 мянган төгрөгийн авлага, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн 10,830.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлүүд тайлагнагдсан байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 188,363.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 352,639.7 мянган төгрөгөөр буурсан байна

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 440,528.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн тайлагнасан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	67,794.3	21,910.9	-45,883.40
Тусгай зориулалттай материал			0.00
Эм боох материал	67,794.3	21,910.9	-45,883.40
Хангамжийн материал	467,709.0	166,452.7	-301,256.30
Бичиг хэргийн материал	3,765.3	1,457.0	-2,308.30
Аж ахуйн материал	31,733.7	40,503.1	8,769.40
Сэлбэг хэрэгсэл			0.00
Түлш, шатах тослох материал	6,550.4	8,087.6	1,537.20
Барилгын засварын материал	1,589.8	3,000.0	1,410.20
Хүнсний материал	28,311.4		-28,311.40
Бусад хангамжийн материал	395,758.5	113,405.1	-282,353.40
Мал амьтад	5,500.0		-5,500.00
Дүн	541,003.3	188,363.6	-352,639.7

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 188,363.6 мянган төгрөгийн 81,9 хувийг ЗДТГ, 12,1 хувийг эмийн эргэлтийн сан, 0,3 хувийг хоршоо хөгжүүлэх сан, 1,6 хувийг Шижир алт цэцэрлэгт сумын төсвөөс бэлтгэж өгсөн барилгын засварын материал, 4.1 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 352,639.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Заамар ЕБС-ийн 155,297.0 мянган төгрөг, Шижир алт сургуулийн 48,759.8 мянган төгрөг, Заамар цэцэрлэгийн 57,133.3 мянган төгрөг, Шижир алт цэцэрлэгийн 75,909.1 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 80,953.1 мянган төгрөг, Соёлын төвийн 22,476.1 мянган төгрөг, нийт 440,528.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг шилжүүлж шийдвэрлэсэн нь нөлөөлсөн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,115,987.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,670,022.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	10,952,889.0	3,384,007.8	-7,568,881.2
Барилга, байгууламж, орон сууц	8,820,972.6	1,819,375.7	-7,001,596.9
Авто-тээврийн хэрэгсэл	435,123.4	560,502.4	125,379.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	514,484.8	387,559.1	-126,925.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	399,645.2	40,703.9	-358,941.3
Зам гүүрний байгууламж	70,040.5	61,363.3	-8,677.2
Бусад үндсэн хөрөнгө	672,361.1	514,503.4	-157,857.7
Ном	40,261.4		-40,261.4
Биет бус хөрөнгө	833,120.6	731,979.8	-101,140.8
Программ хангамж	450.0	300.0	-150.0
Бусад биет бус хөрөнгө	832,670.6	731,679.8	-100,990.8
Дүн	11,786,009.6	4,115,987.5	-7,670,022.1

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн цэвэр үлдэгдэл 4,115,987.5 мянган төгрөгийн 90,6 хувь буюу 3,730,776.1 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 9,3 хувь буюу 383,105.1 мянган төгрөгийг Заамарын хөгжил ОНӨААТҮГ, бусад 0,1 хувь буюу 2,106.4 мянган төгрөгийг ИТХ, эмийн эргэлтийн сан, хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,670,022.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 7,918,499.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж тайлагнасантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Сумын ЗДТГ-т төсвийн хөрөнгөөр 57,330.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ОНХС-гийн санхүүжилтээр 50,000.0 мянган төгрөгийн 2 худаг, 49,850.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 13,890.0 мянган төгрөгийн ундны усны худаг цэвэршүүлэх төхөөрөмж зэрэг нийт 113,740.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр орлого авсан байна.

ХХААГ-аас шинэ хөдөө төслийн хүрээнд 56,309.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 105,872.7 мянган төгрөгийн хадлан тэжээл бэлтгэх иж бүрдэл багц тоног төхөөрөмж, нийт 162,181.8 мянган төгрөгийн хөрөнгийг Заамарын хөгжил ОНӨААТҮГ-т үнэ төлбөргүйгээр орлого авч тайлагнасан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 177,312.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,099.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	976.7	976.7
Ажиллагсадтай холбоотой өр	0	10,262.0	10,262.0
Байгууллагад төлөх өр	162,213.5	166,074.0	3,860.5
Дүн	162,213.5	177,312.7	15,099.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 177,312.7 мянган төгрөг болж, 15,099.2 мянган төгрөгөөр өссөн нь байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн өглөг 7,537.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-т 12,549.3 мянган төгрөгийн, эргэлтийн эмийн санд 976.0 мянган төгрөгийн өглөг шинээр үүссэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдлийн 86,3 хувь буюу 152,956.3 мянган төгрөг нь байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн , 7,1 хувь буюу 12,549.3 мянган төгрөг нь Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын, 6,1 хувь буюу 10,830.4 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлого дахь ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл, 0,6 хувь буюу 976.7 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн өглөг байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант оны өр төлбөр дансны жилийн эцсийн үлдэгдэл 177,312.7 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар бүрэн баримтжуулсан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,077,830.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,688,280.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,104,924.2	2,706,837.0	-1,398,087.2
Хуримтлагдсан үр дүн	7,071,202.4	3,929,762.1	-3,141,440.3
Өмнөх үеийн үр дүн	3,679,057.7	6,421,644.4	2,742,586.7
Тайлант үеийн үр дүн	3,392,144.7	-2,491,882.3	-5,884,027.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,589,984.0	441,231.2	-2,148,752.8
Дүн	13,766,110.6	7,077,830.3	-6,688,280.3

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 6,688,280.3 мянган төгрөгөөр буурсан нь засгийн газрын оруулсан капитал 1,398,087.2 мянган төгрөгөөр буурч, хөрөнгийн дахин үнэлгээ 2,148,752.8 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 2,742,586.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 5,884,027.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Заамар сумын төсвийн байгууллагуудын төсвийн төсөлд 1,643,188.9 мянган төгрөгийн орлого зардлын саналыг төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Хүргүүлсэн төсвийн төслөөс 302,764.9 мянган төгрөгийг бууруулж аймгаас 1,340,424.5 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Сум бүрэн эрхийн хүрээнд төсвийг батлахдаа ОНХС-д 1,313,822.3 мянган төгрөгийг, хоршоо хөгжүүлэх санд 180,000.0 мянган төгрөгийг, сумын ашгаас 938,298.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 3,772,544.3 мянган төгрөгөөр батлагдсан. Аймагт 481,965.6 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн дэмжлэг үзүүлэхээр тогтоолдоо нэмж тусгаснаас, нийт орлогын эх үүсвэр 4,254,509.8 мянган төгрөг баталсан байна..

Заамар сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 2,791,386.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 101,370.0 мянган төгрөг, татварын буцаалтыг 22,068.4 мянган төгрөг, нийт татварын орлогыг 2,870,687.6 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 3,772,544.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 08 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 2,870,035.9 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах нийт зарлагыг 3,855,283.9 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 651.7 мянган төгрөгөөр бууруулж, соёлын төвийн тогтмол зардлыг 1,486.6 мянган төгрөгөөр нэмж, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг 24,362.9 мянган төгрөгөөр бууруулж, сургуулийн тогтмол зардлыг 140,189.9 мянган төгрөгөөр бууруулж, цэцэрлэгийн тогтмол зардлыг 74,156.2 мянган төгрөгөөр бууруулж, ИТХ-ын төлөөлөгчдийн урамшууллын зардалд 77,700.0 мянган төгрөгийг нэмж, ЗДТГ-ын хөрөнгийн зардлыг 159,523.0 мянган төгрөгөөр нэмж, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварыг 82,739.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 1,313,822.2 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 180,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,855,283.9 мянган төгрөгөөр сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Заамар сумын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 26 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 2,870,035.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс аймгийн төсөвт олгох шилжүүлэг 481,965.6 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 730,857.0 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 391,000.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 83,391.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,516,051.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 743,459.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,416,049.3 мянган төгрөг буюу 62,7 хувьтай байгаа нь хөрөнгө оруулалтын зардлын төсвийг 675,106.2 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг 518,838.6 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн төсвийг 176,936.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	214,503.3	180,703.3	33,800.0	84.2%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	602,730.3	582,438.0	20,292.3	96.6%
3	ЕБС-үйлчилгээ	313,730.4	312,458.3	1,272.1	99.6%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	126,510.2	120,689.3	5,820.8	95.4%
5	Соёл урлагийн үйлчилгээ	81,513.3	80,291.9	1,221.4	98.5%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	66,064.7	60,118.0	5,946.7	90.9%
7	Хөрөнгө оруулалтын зардал	956,409.5	281,303.3	675,106.2	29.4%
8	Орон нутгийн хөгжлийн сан	1,313,822.2	794,983.6	518,838.6	60.5%
9	Хоршоо хөгжүүлэх сан	180,000.0	3,063.6	176,936.4	1.7%
	Сумын дүн	3,855,283.9	2,416,049.3	1,439,234.6	62.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар 27,543.1 мянган төгрөг, ИТХ 500.0 мянган төгрөг, Эмнэлэг 20,168.7 мянган төгрөг, нийт 48,211.8 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	84.2%	214,503.3	180,703.3

2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	96.6%	602,730.3	582,438.0
3	Соёл урлагийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	98.5%	81,513.3	80,291.9
4	Ерөнхий боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	99.6%	313,730.4	312,458.3
5	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	95.4%	126,510.2	120,689.4
6	Эмнэлгийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	90.9%	66,064.7	60,118.0
7	Хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр арга хэмжээ	2022 он	хөрөнгийн чанар байдал сайжирна	29.4%	956,409.5	281,303.3
8	Орон нутгийн хөгжлийн сан	2022 он	Цэвэрлэх байгууламж шинэчлэх, Хайлааст багийн хаягжуулалт, гудамжны гэрэлтүүлэг, худаг гаргах, цэцэрлэгт хүрээлэн байгуулах...	60.5%	1,313,822.2	794,983.6
9	Хоршоо хөгжүүлэх сан	2022 он	Эргэж төлөгдөх зээл	1.7%	180,000.0	3,063.6

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд Орон нутгийн зарлагаас давсан орлогоос /ашгаас/ хийгдэх хөрөнгийн зардлын ЗДТГ-аас сумын төвийн Хайлааст багт гэрэлт гудамж байгуулах 346,226.8 мянган төгрөг, Цэнгэлдэх хүрээлэн барих 275,453.6 мянган төгрөг, Эмнэлгийн өргөтгөлийн ажил 29,391.4 мянган төгрөг, Төмстийн багт цахилгаан татах зураг төсөв хийлгэх 34,867.6 мянган төгрөг нийт 685,939.4 мянган төгрөг худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлээгүй байна. Энэ нь барилгын материалын үнэ өссөнөөс тендерт оролцогч аж ахуйн нэгж байгууллага байхгүйгээс шалтгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/12 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Заамар сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 3,855,293.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 57,829.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 43,371.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн жилийн хүрээнд 3 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 44,893.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 10,746.7 мянган төгрөг, албан томилолтын зардлаас 1,052.1 мянган төгрөг хэмнэсэн байна.

ЗДТГ нь тоног төхөөрөмж худалдан авахдаа бага үнийн дүнгээр гэрээ байгуулсны үр дүнд 7,464.0 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 174 мэдээллээс 5 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй төлөвтэй байна. Тендер шалгаруулсан, худалдан авах ажиллагаатай холбоотой 1,075,918.0 мянган төгрөгийн 17 мэдээлэл, 56,375.8 мянган төгрөгийн 29 шийдвэр байршуулсан зөрчилгүй байгаа бөгөөд нэгдсэн тайланд хамрагдагч байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор эмийн эргэлтийн сан, орон нутгийн хөгжлийн сангийн 2 байгууллагад зөвлөмж өгөгдсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.3-д харуулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөний хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 22-ны 1/248 тоотой ирүүлж, fas.audit.mn системд бүрэн хэрэгжсэнээр шивсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0				
Албан шаардлага	0				
Зөвлөмж	3	144,386.7	3	144,386.7	100
Нийт дүн	3	144,386.7	3	144,386.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудлаар Нийгмийн хариуцлагын гэрээгээр хийгдсэн ажлуудыг тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

- Аудитаар нэгтгэсэн тайлангийн харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд буруу тусган илэрхийлсэн 1,325,301.6 мянган төгрөгийн 5 алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулга хийгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн 6.1-д харуулав.

Аудитаар Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 48,594.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсний 9,614.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 30,979.4 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 8,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1.Нэмэлт санхүүжилтийн дансанд он дамнан зарцуулаагүй үлдэгдэл 9,614.9 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх” зарчимтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “ангилал”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Шүүхийн шийдвэрийн дагуу улсын орлогод төвлөрүүлсэн орлогоос тодорхой шийдвэргүйгээр 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 100140012401 тоот дансанд 30.979.4 мянган төгрөгийг шилжүүлэн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-д “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, мөн 6.6-д “Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “толилуулга”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

Аудитаар Заамар сумын нэгтгэсэн тайлангийн 30,979.4 мянган төгрөгийн 1 зөрчил, Заамрын хөгжил ОНӨААТҮГ-ын 436,317.2 мянган төгрөгийн 5 зөрчил, нийт 467,296.6 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Албан шаардлага өгөгдсөн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд төсвийн орлогыг нийт дүнгээр 114,6 хувиар биелүүлсэн боловч, орон нутагт төвлөрүүлэх 6 нэр төрлийн орлогыг 1,7-57.3 хувиар тасалсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бүх шатны төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэх.

2. Худалдан авалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангаас 8,000.0 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй гүйлгээг анхан шатны баримтад нь орлого орж ирсэн тухайн хүний данс руу хийлгүй өөр хуулийн этгээдийн дансанд хүсэлтийн дагуу шилжүүлсэн зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлэх" гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нэр данс зөрүүтэй гүйлгээг тооцоо үүссэн тухай бүрд анхан шатны баримтад нь орлого орж ирсэн тухайн хуулийн этгээдийн данс руу тодорхой шийдвэрийн дагуу, тухайн дүнгээр нь залруулга хийж байх

Аудитаар Заамар сумын нэгтгэсэн тайлангийн 8,000.0 мянган төгрөгийн 2 зөрчил, ЗДТГ-ын 26,300.5 мянган төгрөгийн 2 зөрчил, Заамрын хөгжил ОНӨААТҮГ-ын 46,828.7 мянган төгрөгийн 3 зөрчил, нийт 81,129.2 мянган төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгч, байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 6.2-д харуулав.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	749,327.3			1	749,327.3	1	749,327.3				
ИТХ	1	33,800.0			1	33,800.0	1	33,800.0				
Заамрын хөгжил	2	6,095.4			2	6,095.4	2	6,095.4				
ОНХС	1	536,078.9			1	536,078.9	1	536,078.9				
Дүн	5	1,325,301.6	0	0.0	5	1,325,301.6	5	1,325,301.6				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Засаг дарга	4	48,594.3	1	9,614.9	1	30,979.4	2	8,000.0				
ЗДТГ	2	26,300.5					2	26,300.5				
Заамрын хөгжил	9	483,145.9			5	436,317.2	4	46,828.7	0	0	0	0
дүн	15	558,040.7	1	9,614.9	6	467,296.6	8	81,129.2				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эмийн эргэлтийн сан	1	42,556.1					1	42,556.1
Заамрын хөгжил	1	933,934.0					1	933,934.0
Дүн	2	976,490.2					2	976,490.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0			0	0	0	0
Нийт дүн	2	976,490.2					2	976,490.2

